



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 24 өдөр

Дугаар A/104

Биндэр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий
нэгж талбарыг нэгтгэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үйлчилгээний зориулалттай, газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий 2 нэгж талбарын газрын хэмжээг хүсэлт гаргасан иргэн Баатархүүгийн Насанжаргал (СЖ74042513)-ийн эзэмшлийн газрыг хавсралтын дагуу нэгтгэсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг захирамжаар зөвшөөрөгдөж, нэгтгэгдсэн газрын хэмжээгээр олгож, газар эзэмшүүлэх гэрээ байгуулахыг газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Газар эзэмших гэрээний нөхцөл, зориулалтын дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч иргэн (Б.Насанжаргал)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2014 оны А/25, 2023 оны А/134 тоот захирамжуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

Сумын Засаг даргын 2026 оны
 дугаар сарын 24-ны өдрийн
 1/10 захирамжийн хавсралт

№	Газар эзэмшигч	Регистрийн дугаар	Нэгтгэж буй нэгж талбарын					Нэгтгэсэн нэгж талбарын				
			Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ /м2/	Байршил	Зориулалт	Хугацаа /жил/	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ /м2/	Байршил	Зориулалт	Хугацаа /жил/
1	Б.Насанжаргал	СЖ74042513	2310002744	10000	Хуучин төв	Аялал жуулчлал	60	231000	17766	Хуучин төв	Аялал жуулчлал	38
			2310002851	7766	Хуучин төв	Амралтын газар	40					
	Нийт								17766			